



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар АБХЗ

Улаанбаатар хот

Г Барилга байгууламж албадан  
буулгаж, газар чөлөөлөх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 128/ШШ2022/0845 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 221/МА2023/0072 дугаар магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2023 оны 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүүхийн шийдвэрийг нэн яаралтай биелүүлж, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Оросын Холбооны Улс ашиглаж байсан газар дээр хууль бусаар барьсан "Оргил МГЛ" ХХК-ийн барилга байгууламжийг албадан буулгасугай.

2.Энэ захирамжийн 1-д заасан барилга байгууламжийг албадан буулгах ажлыг дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд шуурхай зохион байгуулахыг "Геодези, усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ (Б.Бямбасайхан)-т, уг ажилтай холбогдуулан орчны аюулгүй байдлыг хангаж, болзошгүй осол, дуу чимээ, доргилт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Онцгой байдлын газар (Г.Галбадрах)-т, нийтийн хэв журмыг сахиулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Э.Товуудорж)-т, албадан буулгахтай холбогдон гарах 1,398,926,258 (нэг тэрбум гурван зуун ерэн найман сая есөн зуун хорин зургаан мянга хоёр зуун тавин найм) төгрөгийн зардлыг зохих журмын дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т, санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725022953





୩୯ ॥ ପାତ୍ରଚନ୍ଦ୍ର ଏହି ଗେଣ୍ଡି ଲିଖାଯାଇଲା ॥

ପାତ୍ରଚନ୍ଦ୍ର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର କାହାର କାହାର । କାହା କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର କାହାର ।  
କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର କାହାର କାହାର । କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର ।

କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର କାହାର । କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର । କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର ।  
କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର କାହାର କାହାର । କାହାର ଏହି ଲାଗୁ କାହାର ।